

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.220.40; 47.080

Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол. Ерөнхий шаардлага	MNS GOST R 58736:2023
Small craft infrastructure. General requirements	GOST R 58736:2019

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн С/03 дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартаар жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлагыг тогтоосон.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.Үүнд:

ГОСТ 12.1.004, *Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;*

ГОСТ 12.1.044, *Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Бодис ба материалын шатах, тэсрэх дэлбэрэх аюул. Үзүүлэлтийн нэршил ба тэдгээрийг тодорхойлох арга;*

ГОСТ 12.3.003, *Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Цахилгаан гагнуурын ажил. Аюулгүй байдалд тавих шаардлага;*

ГОСТ Р 12.4.026, *Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Дохионы өнгөнүүд, аюулгүй тэмдгүүд болон дохионы тэмдэглэгээ. Зориулалт ба хэрэглэх дүрэм. Техникийн ерөнхий шаардлага болон үзүүлэлтүүд. Турших арга;*

ГОСТ 17.1.3.13, *Байгаль хамгаалал. Усан мандал. Гадаргын усыг бохирдлоос хамгаалахад тавих ерөнхий шаардлага;*

MNS 6314:2012, *Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хэрэглэх дохио тэмдэг, төрөл, загвар, нэр томьёо, тодорхойлолт, суурилуулах ба байрлуулах;*

ГОСТ 26775, *Дотоодын усан замын дээгүүр баригдсан гүүрийн доогуур усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөхөд зориулагдсан гарцын овор хэмжээ. Хэм хэмжээ ба техникийн шаардлага;*

ГОСТ Р 50597, *Авто замууд ба гудамж. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлүүдээр зөвшөөрөгдсөн ашиглалтын байдалд тавих шаардлага. Хянах арга;*

MNS GOST R 58736:2023

ГОСТ Р 55561-2013, *Дотоодын усан замын тээвэр. Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын усны барилга байгууламжууд. Аюулгүй байдалд тавих шаардлага;*

ГОСТ Р 57617, *Задгай усан орчин дээрх амралт, зугаалга, соёл, спортын байгууламжууд, тэдгээрийн дэд бүтэц. Нэр томьёо ба тодорхойлолт;*

ГОСТ Р 57618.1, *Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдийн бааз /флот/-ын дэд бүтэц. Нийтлэг дүрмүүд;*

ГОСТ Р 57618.4, *Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдийн бааз /флот/-ын дэд бүтэц. Засвар, үйлчилгээний газрууд. Нийтлэг тавих шаардлага;*

СП 2.13130.2012, *Галын аюулаас хамгаалах системүүд. Хамгаалах объектуудын галд тэсвэртэй байдлыг хангах;*

СП 3.13130.2009, *Галын аюулаас хамгаалах систем. Гал гарсан үед зарлан мэдээлэх болон хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх удирдлагын системүүд. Галын аюулгүй байдалд тавих шаардлага;*

СП 5.13130.2009, *Галын аюулаас хамгаалах систем. Галын дохиолол болон автомат гал унтраагчийг суурилуулах. Хэм хэмжээ болон зураг төсөл боловсруулах дүрэм;*

СП 43.13330.2012, *Үйлдвэрийн барилга, байгууламж. Шинэчлэгдсэн хувилбар СНИП 2.09.03-85.*

ЖИШЭЭ НЬ: Энэхүү стандартыг хэрэглэхдээ эшлэл болгож буй стандартууд нь хүчин төгөлдөр үйлчилж буй эсэхийг олон нийтээр ашиглах мэдээллийн систем - Оросын Холбооны Улсын Техникийн зохицуулалт, хэмжил зүйн Холбооны агентлагийн интернэтийн сүлжээн дэх албан ёсны цахим хуудас, эсхүл тухайн жилийн 1 дүгээр сарын 01-ний байдлаар хэвлэгддэг “Үндэсний стандарт”-ын эмхэтгэл болон сар тутмын “Үндэсний стандарт”-ын лавлагаас шалгах нь зүйтэй юм.

Хэрвээ огноо нь тавигдаагүй эшлэл хийсэн баримт бичиг нь шинэчлэгдсэн бол тухайн баримт бичгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хувилбарыг, түүнд оруулсан бүх нэмэлт өөрчлөлтийг харгалзан ашиглахыг зөвлөж байна.

Хэрвээ огноо нь тавигдсан эшлэл хийсэн баримт бичиг нь шинэчлэгдсэн бол тухайн баримт бичгийн дээр дурдсан батлагдсан (хүлээн зөвшөөрөгдсөн) онд гарсан хувилбарыг ашиглахыг зөвлөж байна.

Хэрвээ энэхүү стандартыг батлагдсаны дараа огноо нь тавигдсан эшлэл хийсэн баримт бичигт өөрчлөлт оруулсан, уг өөрчлөлт нь эшлэл болгосон хэсгийг хөндөж байвал тухайн өөрчлөлтийг харгалзахгүйгээр хэрэглэхийг зөвлөж байна.

Хэрвээ эшлэл болгосон баримт бичгийг шинэчлэхгүйгээр хүчингүй болгосон бол эшлэл болгосон хэсгийг хэрэглэхдээ тухайн эшлэлийг хамаарахгүй хэсгүүдэд хэрэглэхийг зөвлөж байна.

3 Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад ГОСТ Р 57617-2017 (нэр томьёоны), ГОСТ Р 57618.1, ГОСТ Р 57618.4 (засварын бааз, үйлчилгээ, ерөнхий шаардлага) стандартуудад заасан нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1**барилга**

барилгын ажлын үр дүнд бий болсон, газрын дээрх болон газрын доорх хэсгээс бүрдсэн, дотроо өрөө тасалгаа, инженер-техникийн хангамжийн сүлжээ, инженер-техникийн хангамжийн системийг агуулсан, хүмүүс үйл ажиллагаа явуулахад болон үйлдвэрлэл байршуулах, ачаа бараа, материал хадгалахад зориулагдсан томоохон хэмжээний барилгын систем.

3.2**зогсоолын бетон хүзүүвч**

эргийн огцом налууг хашиж эргийг зогсоолын байгууламжтай холбож буй тусад нь байгуулсан богино тавцант -зогсоолын хэсэг. (гуалин дүнзээр жааз зангидаж суурилуулан чулуугаар дүүргэж дээр нь бетон цутгасан хайрцаг)

3.3**битүү агуулах**

дээвэртэй барилга буюу асар, эсхүл тийм барилга доторх өрөө тасалгаа.

3.4**задгай агуулах**

хур тунадас болон нарны туяанаас хамгаалагдсан битүү газарт хадгалах нөхцөлийг шаарддаггүй ачаа барааг хадгалахад зориулагдсан, орц, гарц, гэрэлтүүлэг бүхий бүтээлэгтэй талбай.

3.5**саравч**

тулгуур багануудтай дээвэр, түүний доор байрлах талбай.

3.6**галын аюулын зам**

гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах машинууд явахад зориулагдсан тусгай зам

3.7**бохир ус зайлуулах систем**

бохир усыг хүлээн авч татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэн тунгаах байгууламж бүхий иж бүрэн инженерийн байгууламжийн бүрдэл"-ийг

3.8**гадаргуугийн ус**

хур тунадас орох, цас хайлах, усалгаа хийх болон хатуу гадаргууг угааснаас үүссэн саарал ус

3.9**цэвэрлэх байгууламж**

бохир ус цэвэрлэхэд зориулагдсан байгууламж болон тоног төхөөрөмж

3.10

жигжиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдийн бааз /флот/-ын зогсоолын үйлчилгээний цэг (үйлчилгээний цэг)

усан замын тээврийн хэрэгслийг инженерийн хангалт /ус, цахилгаан, түлш шатахуун, холбоо гэх мэт/ -ын эх үүсвэрт холбоход зориулагдсан зогсоолын тавцан дээр байрлуулсан, техникийн төхөөрөмж

4 Нийтлэг дүрэм

4.1

Зорилго

Стандартын зорилго нь ГОСТ Р 57618.1 стандартын дагуу барьсан жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол нь бага оврын усан замын тээврийн хэрэгслийн дэд бүтцийн бүрдэл хэсгийг тодорхойлоход оршино.

4.2

Зогсоол

Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол /цаашид “зогсоол” гэх/ нь жижиг оврын усан замын тээврийн хэрэгсэл, бусад хөвөгч хэрэгслийг аргамжиж бэхлэх, тэдгээрийг хадгалах, ачаа ачих, буулгах, иргэдийг суулгах, буулгахад зориулагдсан, эрэг дээр болон усан дээрх объектуудын усан бүст байрласан, эргийн болон хөвөгч байгууламжаас бүрдэнэ.

4.3

Зогсоолыг ашиглагч

Энэхүү стандартаар тавигдаж буй шаардлагаас гадна ГОСТ Р 57618.1 стандартын шаардлагын биелэлтийг хангах үүрэгтэй.

4.4

Зогсоолын зураг төслийг боловсруулах

Нутаг дэвсгэрийн багтаамж ба усан бүсийн нөхөн сэргэх хугацаа болон үйл ажиллагааны хэрэгцээнд нийцүүлэн гүйцэтгэнэ.

4.5

Зогсоол байгуулах газар сонгох

Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолыг байгуулах газрыг сонгохдоо дараах үндсэн хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд:

4.5.1 зогсоолын усан бүс нэвт урсгалтай байх, түүний нутаг дэвсгэрт ямар нэгэн тогтоол устай хэсгүүд, тойром үүсээгүй байх;

4.5.2 усны объектуудын усан бүсийн тухайн хэсгийн өгөгдлүүдийг тооцож шинжилсэн усны чанар, түүний усан замын тээврийн хэрэгслийн тооцоолж гаргасан тоонд нөлөөлж буй ус зүйн үзүүлэлтүүдийг.

4.6

Усны объект тус бүрийн хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх Хөдөлгүүрт жижиг усан замын тээврийн хэрэгслүүдийн тоог болон тэдгээрийн ашиглалтыг тогтоосон хэм хэмжээнд нийцүүлэн хязгаарлах ёстой. Нуурууд, усан сан болон тэнгисийн эрэг орчимд моторт жижиг усан замын тээврийн хэрэгслүүдийн зөвшөөрч болох тоо ширхэг (N_H)-ийг дараах томъёогоор тооцож гаргана.

$$N_H = (X * 3DX * F * H * T) / (q * r) \quad (1)$$

Үүнд: X – жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдээс усны объектыг бохирдуулж буй бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хувь хэмжээ (нуур, усан сангийн усан дахь бохирдуулагч бодисын бодит найрлагаас хамааруулан тухайн тохиолдол бүрт тодорхойлно);

$ЗДХ$ – нуур, усан сангийн усан дахь тухайн бохирдуулагч бодисын найрлагын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, мг/л;

F – нуур, усан сангийн талбай, км²;

H – нуур, усан сангийн устай холилдон гарч буй утааны үе давхаргын зузаан, (туршилтын үзүүлэлтээр 0,5 м-тэй тэнцүү гэж авна);

T – хөвөлтийн хугацаа, хоног;

q – хөвөлтийн хугацааны туршид нэг усан замын тээврийн хэрэгслээс ус руу хаяж байгаа бохирдуулагч бодисын дундаж тоо хэмжээ, (туршилтын үзүүлэлтээр 10кг-тай тэнцүү гэж авна);

r – тухайн бодисын хоногт өөрөө цэвэрлэгдэх явцын коэффициент, өөрөөр хэлбэл тухайн бодисыг тодорхой хэмжээгээр цэвэр усанд хийсний дараа уг бодисын найрлага 2.72 -оор багасаж сулрах хугацаа, (уур амьсгалын бүсээс хамаарах ба 20-40 хоногийн хооронд хэлбэлздэг: өмнөд бүст -20 хоног, хойд бүст -40 хоног).

4.7

Усан санд нөлөөлж буй бохирдуулагч бодисын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Гол мөрөн, урсгал сувгуудын усан замын тээврийн хэрэгсэл хөвөх боломжтой хэсэгт зөвшөөрч болох жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдийн тоог, тухайн усан санд нөлөөлж буй бохирдуулагч бодисын сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нөхцөл байдалтай уялдуулан дараах томъёогоор тооцож гаргана.

$$N_r = (X * ЗДХ * Q * L * T) / (q * r) \quad (2)$$

Үүнд: $X, ЗДХ, T, q, r$ – утгууд (1) томъёонд заасантай ижил;

Q – гол, мөрөн, сувгийн усан замын тээврийн хэрэгсэл хөвөх боломжтой хэсгийн урсгалын усны зарцуулалт;

L – жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүдийн тоог тодорхойлоход ашиглаж буй гол, мөрний хэсгийн урт, км;

V – голын урсгалын хурд, м/с.

4.8

Зогсоол нь хөвөлтийн хугацааны туршид баазад байгаа бүх усан замын тээврийн хэрэгслийг усан бүсдээ болон тусгай талбайнуудад байрлуулах, мөн хөвөлтийн улирал хооронд тэдгээрийг хадгалж хамгаалах агуулах, саравчаар хангагдсан байна.

4.9

Зогсоолын технологийн цогцолборын дэд бүтэц дараах объектуудаас бүрдэнэ. Үүнд:

4.9.1 хашлага хаалтын болон эргийг хүчитгэж бэхжүүлж хамгаалсан байгууламж;

4.9.2 албаны болон туслах барилга, байгууламж тоног төхөөрөмж;

4.9.3 инженерийн шугам сүлжээ, харилцаа холбооны хэрэгсэл, дохиолол хамгаалалтын хэрэгслүүд;

4.9.4 боомт доторх үйлчилгээний авто замууд;

4.9.5 усан замын тээврийн хэрэгслүүдийн албаны болон туслах зогсоолын байгууламж;

4.9.6 авран хамгаалах цогцолбор гэх мэт.

4.10

Зогсоолын цогцолборын аюулгүй байдлыг хангах

Зогсоолын технологийн цогцолборын аюулгүй байдал нь түүний бүрэлдэхүүнд орж буй бүх объектуудын аюулгүй байдал, гадаргын усыг бохирдлоос хамгаалах тухай ГОСТ 17.1.3.13 стандартад заасан “усан замын тээврийн хэрэгслүүд болон бусад хөвөгч хэрэгслүүдээс гадаргуугийн усанд бохир усаа асгах, хог хаягдал хаях, тээвэрлэж буй ачаагаа унагаах, түүнчлэн газрын тос, түүгээр үйлдвэрлэсэн шатахуун, тос тосон бүтээгдэхүүн асгахыг хориглоно” гэсэн шаардлагыг хангаж буй байдал, түүнчлэн технологийн цогцолборын дэд бүтцийн объектуудын аюулгүй байдлаар хангагдана.

4.11

Зогсоолын цогцолборын объектуудын байршил

Зогсоолын технологийн цогцолборын объектуудыг зогсоолын нутаг дэвсгэр болон усан бүст бие биедээ харилцан сөргөөр нөлөөлөхгүй байдлаар байршуулна.

4.12

Аюулгүй байдлын шаардлага хангах

Ашиглалтын баримт бичгээр тогтоосон шаардлагыг зогсоолыг ашиглагч, эсвэл түүний ажилтнууд дагаж мөрдөж биелүүлсэн нөхцөлд зогсоолын объектууд нь ашиглалтын (үйлчилгээний)-хаа бүх хугацааны туршид аюулгүй байдлын шаардлагыг хангаж байх ёстой.

4.13

Эрчим хүчний үр ашигтай байдал болон экологийн аюулгүй байдлыг хангах

Зогсоолын технологийн цогцолборын бүх объектын байршил, хийц бүтээц, төхөөрөмж хэрэгслийн тоноглол нь түүний эрчим хүчний үр ашигтай байдал болон экологийн аюулгүй байдлыг хангасан байна.

4.14

Аюултай нөхцөл байдал, эрсдэлтэй бүсүүд

Объектуудын техникийн үзүүлэлтүүд болон хийц бүтээц нь ашиглалтын явцад хүрээлэн буй орчин, усан замын тээврийн хэрэгслүүд, эд хөрөнгө, түүнчлэн зогсоол ашиглагчийн ажилтнуудад аюултай нөхцөл байдал (5 дахь хэсгийг үз) үүсгэх эрсдэлээс сэргийлсэн /минимум болгосон/ байна.

4.15

Зогсоол ашиглагчийн үүрэг

Зогсоол ашиглагч нь /зогсоол ашиглагч хувь хүнээс бусад/ дараах үүрэгтэй. Үүнд:

4.15.1 зогсоолыг аюулгүй ашиглах заавар, дүрмийг боловсруулж батлах, мөрдүүлэх;

4.15.2 зогсоолын хил хязгаар, нэвтрэх орц, гарц, усан замын тээврийн хэрэгслийн зогсох байршлууд болон хөвөлтийн аюулгүй байдлын ба ус цаг уурын нөхцөл байдлын мэдээллээр усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчдыг хангана.

4.16

Зогсоолыг ашиглах дүрэм нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

4.16.1 усан замын тээврийн хэрэгслийн зогсох байршлыг заасан схем /бүдүүвч/;

4.16.2 зогсоолын байгууламжийг ашиглах журам;

4.16.3 галын аюулгүй байдлыг хангах журам;

4.16.4 экологийн аюулгүй байдлын журам;

4.16.5 зогсоолын нутаг дэвсгэр, усан бүсэд холбооны тусгай хэрэгсэл ашиглах журмыг тус тус агуулна.

Зогсоолын схем /бүдүүвч/ бүхий самбарыг зогсоолын нутаг дэвсгэрт байрлуулсан байна.

5 Аюултай нөхцөл байдал, эрсдэлтэй бүс

5.1 Хүрээлэн буй орчинтой холбоотой аюултай нөхцөл байдал

Хүрээлэн буй орчинтой холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.1.1 зогсоолын объектуудаас хүрээлэн буй орчинд үзүүлэх биологи, химийн болон физикийн шинж чанар бүхий аюултай болон хортой хүчин зүйлсийн нөлөөлөл;

5.1.2 зогсоолын технологийн цогцолбор дахь объектуудын техникийн байдалд нөлөөлж буй ус, цаг уурын нөхцөлийн өөрчлөлт.

5.2 Усан замын тээврийн хэрэгсэл

Усан замын тээврийн хэрэгслүүд болон бусад тээврийн хэрэгслүүдтэй холбогдсон аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.2.1 усан замын тээврийн хэрэгсэл (бусад тээврийн хэрэгсэл) зогсоолын технологийн байгууламжтай шүргэлцэх, хавиралдах, мөргөлдсөнөөс (технологийн цогцолборын объектуудын үйл ажиллагаа доголдож ажиллагаагүй болсноос, боомтын технологийн цогцолборын объектуудын тээврийн хэрэгслүүдтэй харилцан үйлчлэлд ордог үзүүлэлтүүд болон хийц бүтээцийг буруу сонгосны улмаас) эвдэрч гэмтэх;

5.2.2 зогсоолын объектууд усан замын тээврийн хэрэгсэл болон бусад тээврийн хэрэгсэлтэй шүргэлцэх, хавиралдах, мөргөлдсөнөөс (усан замын тээврийн хэрэгсэл, бусад тээврийн хэрэгсэл ажиллагаагүй болсны улмаас, эсхүл тэдгээрийг удирдахдаа буруу арга барил хэрэглэсний улмаас) эвдэрч гэмтэх.

5.3 Усан замын тээврийн хэрэгсэл жолооч, багийн гишүүд, зорчигчид, зогсоол дээрх хүмүүс

Усан замын тээврийн хэрэгсэл жолооч, багийн гишүүд, зорчигчид зогсоол дээрх бусад хүмүүстэй холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.3.1 барилга, байгууламжийн хийц бүтээцийн алдаа доголдол болон тоног төхөөрөмж, өргөх-зөөвөрлөх машин механизм ба тоног төхөөрөмж, хэрэгслийн алдаатай буруу үзүүлэлтүүдээс эсхүл тэдгээрийн техникийн бүрэн бус байдлын улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.3.2 хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай иргэдэд үйлчлэх үедээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах.

5.4 Зогсоолыг ашиглагчийн ажилтан

Ашиглагчийн ажилтнуудтай холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.4.1 байгууламж, тоног төхөөрөмжийн хийц бүтээц болон буруу зөрүү үзүүлэлтийн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.4.2 өргөх-зөөвөрлөх машин механизм, тоног төхөөрөмжийн хийц бүтээц болон буруу зөрүү үзүүлэлтийн улмаас иргэд бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.4.3 усан замын тээврийн хэрэгслийн хийц бүтээц болон үзүүлэлтийн буруу зөрүүгийн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах.

5.5 Бодит аюултай хүчин зүйлсийн үйлчлэлийн бүс

Бодит аюултай хүчин зүйлсийн үйлчлэлийн бүсэд дараах бүс хамаарна. Үүнд:

5.5.1 зогсоолын нутаг дэвсгэрээр хийж буй тээврийн хэрэгслийн болон зогсоолын усан бүсэд хийж буй усан замын тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүс;

5.5.2 машин механизм, тоног төхөөрөмж, эсхүл тэдний хэсгүүд, ажиллагааны эд ангиудыг шилжүүлэх хөдөлгөөний бүс;

5.5.3 усан замын тээврийн хэрэгслийн (түүнчлэн өргөгч төхөөрөмж /кран/ бүхий хөлөг онгоцны) хөдөлгөөний доор байрлах талбай;

5.5.4 тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, задалж салгах ажиллагаа явагдаж буй гадаргуу;

5.5.5 газар (усны түвшин, шал, усан замын тээврийн хэрэгслийн тавцан) -ын гадаргуутай харьцуулахад харьцангуй өндөрт байрлах усан замын тээврийн хэрэгслийн жолооч, бусад хүмүүс байрлах бүс эсхүл зогсоол ашиглагчийн ажилтнуудын ажлын байрны бүс;

5.5.6 богино холбоо үүсэж хүн өртөж болзошгүй, хүний биед аюултай хүчдэл бүхий цахилгаан хэлхээ суурилуулсан бүс;

5.5.7 их хэмжээний чичиргээтэй бүс;

5.5.8 их хэмжээний дуу чимээтэй бүс;

5.5.9 их хэмжээний тоосжилттой эсхүл шатдаг хийн бүс;

5.5.10 ослын үед цацагдах шингэн бодис эсхүл халуун уураар хүмүүс түлэгдэж гэмтэж болзошгүй газрууд.

6 Зогсоолын усан бүс

6.1 Ерөнхий зүйл

6.1.1 Зогсоолын усан бүс нь усан замын тээврийн хэрэгсэл түр зогсож хүлээх бүс, зогсоолын байгууламж, усан замын тээврийн хэрэгсэлд цогц үйлчилгээ үзүүлэх байгууламж, хэрэгслүүд, усан замын тээврийн хэрэгслийг усанд тавих, уснаас өргөж гаргах байршил; зогсоолын байгууламжийн усан бүс; зогсоолын усан бүс; усан замын тээврийн хэрэгсэлд үйлчилгээ үзүүлэх байгууламж, хэрэгслүүдийн усан бүс, усан замын тээврийн болон бусад хөвөгч хэрэгслийг усанд тавих, уснаас өргөж гаргах байршлын усан бүс, тэдгээрт нэвтрэх орц, гарцуудаас тус тус бүрдэнэ.

6.1.2 Зогсоолын усан бүс нь усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөх төв замын хөдөлгөөний хил хязгаараас гадуур байрлана.

6.1.3 Зогсоолын усан бүст дараах шаардлагууд хангагдсан байна. Үүнд:

6.1.3.1 зогсоолын усан бүсийн хил хязгаарыг маш тодорхой тэмдэглэсэн байх;

6.1.3.2 зогсоолын усан бүсийн усны гүн нь хөвөлтийн улиралд усан замын тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэн орох, гарах нөхцөлийг хангаж байх;

6.1.3.3 зогсоолын усан бүсийн хил хязгаарын дотор усан замын тээврийн хэрэгслийн хөвөлт /навигаци/-ийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай – гол зам, хүлээх хэсэг, усан замын зогсоол зэргийг маш тодорхой тэмдэглэсэн байна.

6.1.4 Усан бүс дэх хөвөгч зогсоолууд нь найдвартай бат бөх бэхлэгдсэн, эрэг талаас түүнд нэвтрэн орох эсхүл зогсоолын үйлчилгээний тээврийн хэрэгслээр хүрэлцэн очих нөхцөлийг хангасан байна.

6.1.5 Зогсоолын дэргэд усан замын тээврийн хэрэгсэл эргэх үйлдэл хийх орон зай байхгүй тохиолдолд, түүний ойр орчимд усны урсгалын доод талд, эсхүл усны урсгалын дээд талд эргэлтийн манёвр хийх зориулалттай зогсох хэсэг (рейд)-ийг байгуулахыг зөвшөөрч болно.

6.1.6 Усан бүсийн усны гүн нь шаардлагатай тохиолдолд усан замын тээврийн хэрэгслүүд /флот/- ийн өвлийн сул зогсолтын нөхцөлд тохирсон байх ёстой.

6.1.7 Зогсоолын усан бүс, тухайн бүсэд зогсож буй усан замын тээврийн хэрэгслүүд, зогсоолын нутаг дэвсгэр, байгууламж зэргийг хүчтэй давлагаа, цөн түрэлт, үерийн ус, далайн шуурга, хүчтэй салхи, давлагааны үйлчлэлээс, мөн усан замын тээврийн хэрэгслүүд, бусад хөвөгч хэрэгслүүдийг дайвалзал налалт,

MNS GOST R 58736:2023

цохилтоос болон усан дээр хөвж буй эд зүйлстэй мөргөлдөх аюул ослоос тус тус хамгаалах, түүнчлэн боомтын усан бүсийг элс, шаварт автагдах эрсдэлийг багасгах зорилгоор хамгаалалтын байгууламж (овоолсон далан, чулуун далан, давлагаа сааруулагч, мөс зүсэгч) барьж байгуулж болно.

6.1.8 Хамгаалалтгүй усан бүс дэх давлагааны жилийн дундаж хэвийн өндөр нь 0,3 м-ээс дээш байх тохиолдолд давлагаанаас хамгаалах байгууламж барьж байгуулна.

6.1.9 Зогсоолын усан бүсийг салхи, давлагаанаас хамгаалахын тулд давлагаа сааруулагчийг хэрэглэнэ.

6.1.10 Давлагаа сааруулагчийн төрлийг сонгох нь тухайн бүс дэх давлагааны түрэлтийн алслах зай, салхи болон давлагааны нөхцөл байдал, эргийн шугамын тогтцоос хамаардаг.

6.1.11 Давлагаанаас хамгаалах үндсэн аргууд. Үүнд:

6.1.11.1 байгалийн чулуу, буталсан чулуу эсхүл тусгайлан бэлтгэсэн төмөр бетон блок (тетраэдр)-ыг овоолсон далан хэлбэртэй давлагаа сааруулагч байгуулах, ингэхдээ овоолсон далангийн өндөр нь давлагааны хамгийн өндөр шовх оройгоос дээш нэг метрээс багагүй хэмжээгээр өндөр байх ёстой;

6.1.11.2 хүнд төмөр бетон хөвөгчүүдэд суурилуулан хөвдөг давлагаа сааруулагч байгуулах;

6.1.11.3 бетонон хавтан, модон хавтан, металл хавтан зэрэг дурын материалаар хийсэн хавтанг тулгуур шонд, хавтангийн дээд ирмэг нь хамгийн өндөр давлагааны шовх оройгоос дээш өндөрт, хамгийн доод ирмэг нь давлагааны хамгийн нам цэгээс дор байхаар бэхэлж суурин “хашаа” байгуулах;

6.1.11.4 олон тооны нүхтэй самбар хавтан (эсхүл олон тооны нүхтэй төмөр сараалж)-г давлагааны хүчийг сааруулагч болгон ашиглах;

6.1.11.5 бетон эсхүл металл хийцтэй босоо хана.

Жишээ нь:

а) Овоолсон далан хэлбэртэй давлагаа сааруулагчийн дотор талаас нь хашиж ханан зогсоол, эсхүл эрэг дагуу бетондсон далан, гудамж байгуулж болно.

б) Хүнд төмөр бетон хөвөгчүүд нь богино нам давлагааг сааруулж, давлагааны өндрийг 80% хүртэл багасгах боловч хүчтэй, урт давлагааг төдийлөн сааруулж чадахгүйгээр тэдгээртэй зэрэгцэн хөвөх талтай.

с) Бетон эсхүл металл хийцтэй цул босоо хана нь давлагааг ойлгох үйлчлэл үзүүлнэ. Зарим нөхцөл байдалд үргэлжилсэн цуваа хэлбэртэй хамгаалалтыг зайлшгүй хэрэглэх, тухайлбал овоолсон далан болон хөвдөг давлагаа сааруулагчийг ашиглах шаардлагатай.

6.2 Зогсоолын усан бүс

6.2.1 Зогсоолын усан бүс аюулгүй ажиллагааны дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.2.1.1 усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоож аргамжиж бэхлэх үед;

6.2.1.2 усан замын тээврийн хэрэгсэл зогсоолоос хөдлөх үед.

6.2.2 Зогсоолын усан бүсийн урт нь үйлчлүүлэх усан замын тээврийн хэрэгслийн урт ба түүнд үйлчилгээ үзүүлэх зориулалтад нийцсэн байна.

6.2.3 Хоорондоо залгаа орших зогсоолуудын усан бүсүүдийн эргэлтийн өнцөг нь усан замын тээврийн хэрэгсэл зогсоолд зогсох, зогсоолоос хөдлөх үеийн аюулгүй байдлыг хангасан байна.

6.2.4 Зогсоолын усан бүсийн өргөнийг усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөх гол замын зах эсвэл усан замын орц, гарц хүртэл тодорхойлохдоо зогсоолуудын эрэгтэй харьцуулсан байрлал, усан замын тээврийн хэрэгсэл зогсоолоос хөдлөх үедээ эргэлт хийх зайлшгүй шаардлага, зогсоолуудын ойр орчимд зогсоол руу шахагч урсгал байгаа эсэх, усан замын тахиралдсан байдал зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

6.2.5 Усан замын тээврийн хэрэгсэл нь зогсоолоос хөдлөхдөө эргэлт хийх зайлшгүй шаардлагатай, тусгай үндэслэл байгаа тохиолдолд усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөх усан замын усан бүсэд эргэх үйлдэл хийхийг зөвшөөрнө.

6.2.6 Зогсоол орчмын усан бүсийн усны гүн нь усан замын тээврийн хэрэгсэл зогсоолд аюулгүй зогсох нөхцөлийг хангасан байх ба дараах зүйлийг тооцсон байна. Үүнд:

6.2.6.1. усан замын тээврийн хэрэгслийг даацынх нь хэмжээгээр бүрэн ачаалсан үеийн суулт;

6.2.6.2. усан замын тээврийн хэрэгслээс ачаа буулгах, ачаа ачихтай холбоотойгоор үүсэх, түүний хошуу болон сүүл хэсгийн суултын өөрчлөлт болон усан бүс дэх хог хаягдлыг тооцож усны гүнийг тогтоох;

6.2.6.3. давлагаатай үед усан замын тээврийн хэрэгсэл хайрдахгүй байхаар усны гүнийг тооцох;

6.2.6.4. хүчтэй салхины нөлөөгөөр усны түвшин өөрчлөгдөхийг тооцож усны гүнийг хангалттай авах;

6.2.6.5. усан замын тээврийн хэрэгслийн ёроолын усан доорх хөдөлгөөнийг тооцож усны гүнийг хангалттай байлгах.

6.3 Зогсоолд усаар нэвтрэх орц, гарц

6.3.1 Зогсоолд усаар нэвтрэх орц, гарц нь усан замын тээврийн хэрэгслүүд ямар нэгэн саадгүйгээр хөвж хөдөлгөөнд оролцон зогсоолын усан бүст орж гарах

MNS GOST R 58736:2023

боломжийг олгосон байна. Зогсоолын орц, гарц нь аюулгүй бөгөөд хөвөлтийн улирлын турш усан замын тээврийн хэрэгслүүд үйлчлүүлэх боломжтой байна.

6.3.2 Усан замын орц, гарц нь усан замын тээврийн хэрэгсэл ба усан замын тээврийн хэрэгслийн цувааны хоёр талын хөдөлгөөнийг хангаж байх ёстой. Түүнчлэн салаалах төхөөрөмж ашиглан хөдөлгөөний нэг талын урсгалыг явуулж болно.

6.3.3 Усан замын тахиралдсан хэсгийн өргөнийг түүний шулуун хэсгийн өргөнтэй харьцуулж, түүний утгаар нэмэгдүүлж тооцно.

6.3.4 Зогсоолд нэвтрэх орц, гарц дахь гол усан замын усны мандал дээрх хэмжээ нь ГОСТ 26775 стандартын шаардлагыг хангасан байна.

6.3.5 Усан замын тэнхлэгээрээ дугуйрах, тахиралдах хамгийн бага радиус нь өөрөө явагч усан замын тээврийн хэрэгсэл, чирүүлж буй усан замын тээврийн хэрэгслийн цуваан дахь хамгийн том оврын усан замын тээврийн хэрэгсэл болон түлхэгдэж буй усан замын тээврийн хэрэгслийн цуваа аюулгүй өнгөрөх боломжийг хангасан байна.

6.4

Хөвөлт /навигаци/ -ийн орчны аюулгүйн нөхцөл байдал

6.4.1 Зогсоолын усан бүсийн хөвөлтийн орчны аюулгүйн нөхцөл байдал нь усан замын тээврийн хэрэгслүүд хөвөхөд аюулгүй, саадгүй байх нөхцөлийг хангаж, зогсоол, гидротехникийн байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах ёстой.

6.4.2 Хөвөлтийн орчны аюулгүйн нөхцөл байдлыг илтгэж буй эргийн болон хөвөгч тэмдгүүд, түүнчлэн чиглүүлэгч гэрэлт цамхгийн үйл ажиллагааг хөвөлтийн улирлын турш хангасан байна.

6.4.3 Дотоодын усан замын хөвөлт /навигаци/ -ийн орчны аюулгүйн бүх нөхцөл байдлыг илтгэж буй гэрэл дохио ба тэмдгүүдийн хэлбэр, хэмжээ, өнгө, үзүүлэлтүүд нь MNS 6314:2012 стандартын шаардлагыг хангасан байна.

6.4.4 Хаврын шар усны халиа болон үерийн усанд автаж дарагдаж болзошгүй хашлага, хаалт, хамгаалалтын байгууламжуудыг усанд автагдах үед нь нөхцөл байдлыг /дээд хязгаарыг/ нь илтгэсэн тэмдгүүдийг байрлуулна.

7 Зогсоолын нутаг дэвсгэр

7.1 Эрүүл ахуй, халдвар хамгааллын бүс

7.1.1 Зогсоолууд, тэдгээрийн нутаг дэвсгэр дээрх объектууд эрүүл ахуй, халдвар хамгааллын бүстэй байж болно.

7.1.2 Зогсоолууд, тэдгээрийн объектуудын эрүүл ахуй, халдвар хамгааллын бүсийг “СанПиН 2.2.1/2.1.1.1200-03 Эрүүл ахуй - халдвар хамгааллын бүсүүд ба үйлдвэр, байгууламж болон бусад объектуудын эрүүл ахуй -ариун цэврийн ангилал”-д нийцүүлэн зогсоолыг ашиглагч тогтооно.

7.2 Зогсоолын нутаг дэвсгэрт тавих шаардлага

7.2.1 Зогсоолын нутаг дэвсгэрийг хаалт, хашаагаар тусгаарлаж хамгаалсан байна.

7.2.2 Зогсоолын нутаг дэвсгэр нь “СНиП III-10-75, Үйлдвэрлэл явуулах дүрэм ба ажлыг хүлээн авах. Нутаг дэвсгэрийг тохижуулах” шаардлагад нийцсэн байна. Зогсоолууд, тавцан, талбай, автозам, орц, гарц, явган хүний замууд хатуу, тэгш, халтиргаагүй, ус зайлуулах налуу бүхий гадаргуутай байна. Нутаг дэвсгэрийг хамгаалах, инженерийн бэлтгэлийн бүрдэл хэсгүүдийн зураг, төслийг гаргахдаа гадаргуугийн ус зайлуулах болон эргийн шугамын хэлбэрийг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд гүйцэтгэнэ.

7.2.3 Нутаг дэвсгэр нь хашаагаар тусгаарлагдсан зогсоолын орц, гарцад шалган нэвтрүүлэх дэглэм зохион байгуулна.

7.2.4 Зогсоолын нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоогүй орон сууцны, худалдааны, соёл-амралтын, эмнэлгийн болон бусад барилга барихыг хориглоно.

7.2.5 Нутаг дэвсгэрт нь эргэх үйлдэл хийх талбай байхгүй бол зогсоолд хоёроос доошгүй орох хаалгатай байхаар урьдчилан төлөвлөсөн байна.

7.2.6 Зогсоолоос тээврийн хэрэгсэл гарах, орох дэлгэмэл хаалгыг суурилуулахдаа дотогшоо нээгдэж байхаар хийх бөгөөд хаалга өөрөө хаагдах боломжгүй байна.

7.2.7 Автомашин нэвтрэн ороход зориулагдсан хаалганы өргөнийг зогсоолын нутаг дэвсгэрт нэвтрэн орох хамгийн том оврын автомашины өргөн дээр 1,5 м-ийг нэмж тооцон авах ба гэхдээ хаалганы нийт өргөн нь 4,5 м-ээс багагүй байх ёстой.

7.2.8 Зогсоолын нутаг дэвсгэрийн хил хязгаарын тэмдэглэгээ нь усан замын зогсоолын зориулалт, залгаа орших нутаг дэвсгэрийн тогтоц, ашиглаж буй технологийн тоног төхөөрөмж гэх мэтийг тооцсон, усны болзошгүй бүх түвшин ба цөн түрэлтийн үед эргийн объектуудын аюулгүй байдлыг хангасан байна.

7.2.9 Усанд автдаг талбайг усан замын суурин эсхүл хөвөгч дохио тэмдгүүдээр тоноглож хаших шаардлагатай.

7.2.10 Зогсоолын нутаг дэвсгэрийн өргөнийг, ачиж буулгах машин механизм, авто тээврийн хэрэгслүүдийн зам ба тэдгээрийн зогсох, эргэх үйлдэл /маневр/ хийх талбай, агуулахууд, үйлдвэрлэлийн зориулалттай болон албаны барилга байгууламжуудыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартууд, эрүүл ахуй, галын аюулаас хамгаалах болон бусад стандарт, хэм хэмжээнд нийцүүлэн байрлуулах нөхцөлийг харгалзан тодорхойлно.

7.2.11 Эргийн зогсоолын зогсох хэсгүүдэд усан замын тээврийн хэрэгсэл ойртож дөхөхөд хялбар байдлаар зогсоолын нутаг дэвсгэрийг төлөвлөнө.

7.2.12 Ус хүлээн авах эсхүл ус зайлуулах тоног төхөөрөмж байгаа үед гадаргуугийн усыг урсгаж зайлуулах нөхцөлийг хангах зорилгоор нутаг дэвсгэрийг ус хүлээн авах эсхүл ус зайлуулах тоног төхөөрөмжийн зүгт налуу байдлаар төлөвлөнө.

7.2.13 Зогсоолын нутаг дэвсгэр дээрх техникийн зориулалтаар төлөвлөсөн нүх шуудуу болон бусад хонхор нь бат бөх нягт хаалттай эсхүл хашлагатай байна.

7.2.14 Өндөр, нам буюу дээр доор түвшинд байрладаг нутаг дэвсгэр бүхий зогсоолуудын түвшин хоорондын зөрүүгийн налуу зам (пандус) дээр авто эсхүл цахилгаан ачигч механизм хэрэглэх үед болон автотээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөнтэй үед налуу нь 60 промилль -ээс хэтрэхгүй, байнгын бус хөдөлгөөнтэй үед зөвхөн автотээврийн хэрэгсэлд налууг 90 промилль хүртэл байхыг зөвшөөрнө.

7.2.15 Гал унтраах арга хэмжээ авах болон гал унтраах машинууд усан бүсээс ус соруулах боломж нөхцөлийг хангах зорилгоор, хэрвээ зураг төслөөр өөр шийдлийг төлөвлөөгүй бол, гал унтраах машиныг усан бүс, нутаг дэвсгэрийн хил хязгаарт хялбар ойртож очих боломжийг хангасан байна.

7.3 Усан замын зогсоолын технологийн цогцолборын барилга, байгууламжид тавих шаардлага

7.3.1 Аж үйлдвэрийн барилга байгууламжтай ижил төстэй усан замын зогсоолын объектууд (засвар үйлчилгээний газар, гараж, цахилгааны станц, уурын зуух, инженерийн хангамжийн талбай доторх болон гаднах шугам сүлжээ г.м.) нь үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтад тавигддаг “Барилга, байгууламжийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлага”-ыг хангасан байна.

7.3.2 Усан замын тээврийн хэрэгслийг түлш шатахуунаар цэнэглэхдээ эргийн болон хөвөгч ШТС-ыг ашиглах бөгөөд эргийн ШТС нь усан замын объектуудаас 100 м-ээс ойр байрлаж болохгүй.

7.3.3 Хөвөгч ШТС-ыг ашиглах үедээ дараах шаардлагыг мөрдөнө. Үүнд:

7.3.3.1 шатахуун тээвэрлэгч тээврийн хэрэгсэл очих замтай байх;

7.3.3.2 шатахуун тээвэрлэгч тээврийн хэрэгсэл зогсож, түлш шатахуунаа юүлэх, технологийн дагуу өндөрлөсөн тэгш талбайтай тавцантай байх;

7.3.3.3 0.4 кВ-ын хүчдэлтэй цахилгаан хангамжийн сүлжээнд холбосон байх;

7.3.3.4 усан бүсийн усны гүн 1,5м-ээс багагүй байх;

7.3.3.5 усны ёроол алсуур налуу үед хөвөгч эсвэл байнгын тавцант зогсоол барих.

7.3.4 ШТС нь зогсоол дээр байрлаж буй бүх усан замын тээврийн хэрэгслийн төрөл тус бүрийг түлш шатахуунаар цэнэглэх боломжтой байна.

7.3.5 ШТС нь усан бүсээс ил тод харагдах “Хурдаа хас” гэсэн самбартай хаягтай байна.

7.3.6 Хүнд, овор ихтэй ачаа хадгалах, түлш шатахуун ачих буулгах өдөр тутмын үйл ажиллагаа явуулах өрөө нь халаалттай байна.

7.3.7 Өдөр тутмын үйл ажиллагаа явуулах өрөөнд төрөл бүрийн сэлбэг хэрэгсэл, эд анги хадгалахад зориулсан тусгай тасалгаатай байна.

7.3.8 Засвар – механикийн газрын галын аюултай болон тэсрэх дэлбэрэх аюултай өрөө тасалгааны ханыг даацын ханаар тусгаарласан байна.

7.3.9 Засвар – механикийн газрын хаалгыг дулаалгын хөшиг унжуургаар хаалт хийсэн байна.

7.3.10 Засвар – механикийн газрын задгай талбайнууд хатуу гадаргуутай байна.

7.3.11 Галын аюулын дохиоллын болон галын аюулын тухай зарлан мэдээлэх системтэй байна.

7.3.12 Технологийн цогцолборын барилгын халаалтын системийг ажлын бус цагаар өгч буй дулааны урсгалыг тохируулдаг системээр тоноглож болно.

7.4

Зогсоолын тавцант байгууламжид тавих шаардлага

7.4.1 Зогсоолын тавцант байгууламж нь эргийн болон хөвөгч байж болно.

7.4.2 Зогсоолын тавцант байгууламжийн хийц бүтээц, тоног төхөөрөмж ГОСТ Р 55561 стандартад заасан усны барилга байгууламжид тавигддаг аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

7.5

Усан замын тээврийн хэрэгслийн зогсоолд зогсох байршил

7.5.1 Усан замын тээврийн хэрэгслийг эрэг дээр задгай талбайд, асар дор, халаалтгүй болон халаалттай засварын газар, байгууламжид хадгална.

7.5.2 Усан замын тээврийн хэрэгслийг зогсоолын усан бүсийн усны мандал дээрх хөвөгч тавцангууд дээр болон өргөх тоног төхөөрөмжийн тусламжтайгаар өргөж хуурай хадгална.

7.5.3 Задгай талбай дээрх зогсоолын эгнээ хооронд дурын усан замын тээврийн хэрэгслийг нэвтрэн өнгөрүүлэх, усан замын тээврийн хэрэгслийг зогсоож байрлуулах, байрлалаас нь гаргахтай холбогдсон маневр хийх хангалттай орон зайтай байна.

7.5.4 Задгай талбай дээрх замууд нь хатуу хучилттай байна.

7.5.5 Задгай талбай дээрх зогсох байрлалуудыг овор хэмжээгээр нь бүлэглэнэ.

7.5.6 Зогсох байрлалуудын хоорондох зай нь усан замын тээврийн хэрэгсэлд ачаа ачих, буулгах зай, хүмүүс буух суух шатны өргөн зэргийг тооцсон, усан замын тээврийн хэрэгсэл нэг бүрийг тойрч хүн явах боломжийг хангасан байна.

7.5.7 Задгай талбайд цахилгааны хуваарилалт болон усан хангамж, гал унтраах тоног төхөөрөмж, хэрэгсэл ба гал унтраах машин явах замтай байх ёстой.

7.5.8 Засвар үйлчилгээний халаалтгүй байгууламж - бүх талаараа битүү хаалттай, агаарын үйлчлэл нөлөөнөөс хамгаалагдсан өрөө, тасалгаа болно.

7.5.9 Засвар үйлчилгээний халаалтгүй байгууламжийг жилийн хүйтэн улиралд ч дулаанаар хангахгүй.

7.5.10 Засвар үйлчилгээний байгууламжийн хана, дээврийг дулаан тусгаарлагчтай хийсэн байх ёстой.

7.5.11 Хүйтний улиралд усан замын тээврийн хэрэгслийг халаах боломжтой агааржуулагчийн системээр тоноглогдсон усан замын тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээний халаалтгүй байгууламжид тусад нь байрлуулна.

7.5.12 Засвар үйлчилгээний байгууламжийн хаягдал ус зайлуулах худгийн ширмэн сараалж торон тагуудыг усан замын тээврийн хэрэгслийг зөөвөрлөж буй хүнд машин техникийн дугуйнд дайрагдахааргүй суурилуулсан байна.

7.5.13 Өргөх машин механизмын тоног төхөөрөмжид хамаардаг, усан замын тээврийн хэрэгслийг өргөж хадгалах систем нь үйлдвэрийн аюултай объектуудын үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн шаардлагад нийцсэн байна.

7.5.14 Засвар үйлчилгээний байгууламжийн дээврийг цас хайлах үед хаалганы өмнө дусаал гоожиж, овгор мөс тогтохоос урьдчилан сэргийлсэн байдлаар барьсан байна.

7.5.15 Өвөл нь их хүйтэн болдог бүс нутгуудад засвар үйлчилгээний халаалттай байгууламжийг ашиглана.

7.5.16 Усан замын тээврийн хэрэгслийн өвлийн хадгалалтын үед халаалтын систем нь засвар үйлчилгээний байгууламж дотор 5°C, түүнээс илүү хэмийн дулаанаар хангаж байх ёстой.

7.5.17 Засвар үйлчилгээний байгууламжийн хэмжээ /урт, өргөн, өндөр/-г дараах нөхцөлийг харгалзан тодорхойлно. Үүнд:

7.5.17.1 усан замын тээврийн хэрэгслүүдийг байрлуулахаар өгөгдсөн газрын байршил, хэмжээ;

7.5.17.2 усан замын тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээний байгууламж дотор оруулж байрлуулах, түүнээс гаргахаар сонгож авсан технологи;

7.5.17.3 үйлчлэхээр төлөвлөж буй усан замын тээврийн хэрэгслүүдийн овор хэмжээ, тоо ширхэг.

7.5.18 Засвар үйлчилгээний байгууламж нь аль болох цөөн тооны тулгуур баганатай байна.

7.5.19 Засвар үйлчилгээний байгууламжийн хаалганы өндөр, өргөн нь хадгалах хамгийн том оврын усан замын тээврийн хэрэгслийн хэмжээнд нийцэж байна.

7.5.20 Засвар үйлчилгээний байгууламж доторх тавиурууд дээр усан замын тээврийн хэрэгслийг байрлуулж хадгалах үед тавиуруудын байршил, үзүүлэлтүүд нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

7.5.21 Зогсоолын нутаг дэвсгэрээр усан замын тээврийн хэрэгслийг шилжүүлэн зөөвөрлөх хөдөлгөөнийг түүний эзэмшигч /ашиглагч/-ийн автомашины чиргүүл /тоног төхөөрөмж/-өөр эсхүл зогсоол ашиглагчийн машин тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

7.5.22 Усан замын тээврийн хэрэгслийг усанд тавих, уснаас гаргахдаа зам төмөр суурилуулсан тусгай налуу тавцан ашиглах буюу зогсоол ашиглагчийн шилжүүлэн ачих тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

7.5.23 Зам төмөр суурилуулсан тусгай налуу тавцангийн хэмжээ болон ачаалж болох даацын хэмжээ нь усанд тавихаар, эсхүл уснаас гаргахаар төлөвлөж буй усан замын тээврийн хэрэгслийн овор хэмжээ, хүндийн жин ба өргөх буулгах машин тоног төхөөрөмжийн үзүүлэлтүүдэд нийцсэн байна.

7.6 Агуулахад тавих шаардлага

7.6.1 Усан замын зогсоолын агуулахын барилга, байгууламж нь үйлдвэр, байгууламж, бусад объектын эрүүл ахуй -ариун цэврийн халдвар хамгааллын бүст болон барилга, байгууламжийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлагыг хангасан байна.

7.6.2 Хоорондоо үл зохицох материалуудыг агуулахуудад тус тусад нь хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.6.3 Агуулахуудын зэрэглэл, бүсүүдийн ангилал буюу тэсэрч дэлбэрэх болон гал түймрийн аюултай хэсгүүд нь Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага, MNS 4223:1994 Тэсрэх бодис. Техникийн шаардлагад заасны дагуу тэдгээрт хадгалах материалын шинж чанарт нийцсэн байна.

7.6.4 Агуулахын зориулалттай задгай талбайн налуу нь 5 промилле-ээс багагүй, 20 промилле-ээс ихгүй байна.

7.6.5 Зогсоолын доторх бүх талбай, явган хүний зам, тээврийн хэрэгслийн зорчих зам нь хатуу хучилттай байх ба хучилтын төрлийг тогтоохдоо цаг уурын нөхцөл, дотоодын зах зээлд байгаа барилгын материал болон тээврийн хэрэгслийн үзүүлэлтийг харгалзан тогтооно.

7.6.6 Битүү агуулахууд болон албан барилгуудын шалны тэмдэглэгээ нь үерийн усны оргил түвшнээс доошгүй, хэтрэх магадлал 0,5%-5,0% байна. Агуулах болон албан барилгуудын шалны түвшингийн тэмдэглэгээ нь боомтын нутаг дэвсгэрийн тэмдэглэгээнээс доош байх ёсгүй.

7.6.7 Агуулахуудын хаалгыг нээх, хаах, шаардлагатай байрлалд зогсооход аюулгүй, удирдаж ажиллуулахад хялбар, ашиглахад найдвартай тоноглол хэрэгслээр тоноглогсон байна.

7.6.8 Агуулахын барилгын хийц, бүтээцийн бүрдэл хэсгийг будах өнгийг MNS 4643:1998 Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө стандартад нийцүүлэн зураг төсөлд тусгаж төлөвлөсөн байна.

MNS GOST R 58736:2023

7.6.9 Битүү агуулахын шал болон ачаа ачих буулгах машин тээврийн хэрэгсэлд орж ачаа ачих, буулгах, агуулахаас ачаа зөөж гаргах, оруулахад зориулагдсан налуу талбайг хатуу, тэгш, гулсдаггүй материалаар бүрсэн байх ёстой ба ус зайлуулах налуу нь 15 промилле -ээс хэтрэхгүй байна.

7.6.10 Хүнд даацын дугуйтай ачигч машин механизм, чирэгч машин механизм болон аккумуляторт тэргэнцэр ажиллахад зориулан агуулахын шалыг асфальт, бетон эсхүл модон хучилттай байхаар төлөвлөнө. Даралтат хийт зөөлөн дугуйтай машин ашиглах тохиолдолд агуулах нь хатуу хучилттай шалтай байх ёстой.

7.6.11 Агуулахын хаалганы тээврийн хэрэгсэл явж өнгөрөх хэсэгт ачигч машин механизм болон ачаа зөөж, тээвэрлэх бусад төрлийн өөрөө явагч машиныг орох хэсэгт хөдөлгөөнд саад болох эд зүйл байх ёсгүй.

7.6.12 Гэрэлтүүлгийн хагарсан эсхүл шатсан гэрлийг солиход аюулгүй ажиллагааг хангах зориулалттай зөөврийн хөнгөн өргөгч механизм (эсхүл өөр төрлийн төхөөрөмж) агуулахад байх ёстой.

7.6.13 Агуулахын өрөөнүүдэд, түүний дээврээс борооны ус зайлуулах хоолойг төлөвлөсөн байна.

7.6.14 Нутаг дэвсгэр, зам, тээврийн хэрэгслийн зорчих зам, задгай талбай дээрх ажлын байрны хоногийн харанхуй цагийн гэрэлтүүлэг нь Хүснэгт 1-т заасан шаардлагыг хангасан байна.

1-р хүснэгт - Усан замын зогсоолын нутаг дэвсгэрийн гэрэлтүүлэг

Объект	Хамгийн бага гэрэлтүүлэг /лк/	Гэрэлтүүлэг хэвийн байх хавтгай	Тайлбар
Зам	0,5	Тээврийн хэрэгсэл явж өнгөрөх хэсгийн түвшинд	-
Авто тээврийн хэрэгсэл болон барилгын машин механизмын зогсоол, ажил гүйцэтгэж буй бүс дэх зам, талбай	2	Гэрэлтүүлж гадаргуугийн түвшинд буй	
Шат, гүүрэн гарц	3	Гэрэлтүүлж гадаргуугийн түвшинд буй	
Усан замын тээврийн хэрэгсэлд тоног төхөөрөмж, бүрдэл хэсгийг ачиж, буулгах	10	Хэвтээ	Хүлээн авах, хүлээлгэн өгөх талбайд

7.6.15 Гэрэлтүүлгийн шугам сүлжээнд “Цахилгаан тоног төхөөрөмж суурилуулалтын дүрэм”-д заасан цахилгааны системийг ашиглана.

7.6.16 Гагнуурын ажлыг ГОСТ 12.3.003 стандартад заасан цахилгаан гагнуурын ажил гүйцэтгэх үед баримтлах Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

7.7 Авто замд тавих шаардлага

7.7.1 Замын өргөн нь ашиглах тээврийн хэрэгсэл, эсрэг талын тээврийн хэрэгслийн урсгалыг тооцсон хөдөлгөөний эрчим, шилжүүлэн зөөх усан замын тээврийн хэрэгслийн овор хэмжээнд нийцсэн байна. Боомтын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зорчих зам, явган хүний зам, орц, гарц болон аюултай бүсийн хаалт хашлагыг заасан тэмдэг тэмдэглэгээг суурилуулсан байх ба түүнчлэн шөнийн цагт урьдчилан сэргийлж анхааруулсан мэдээлэл, хаяг, самбар нь гэрэлтүүлэгтэй байна.

7.7.2 Явган зорчигчдыг гол замын дагуу зорчиход нь зориулж замын нэг талд нь 1,5м-ээс багагүй өргөнтэй явган хүний зам төлөвлөнө. Уг зам нь гол замын хучилтаас дээш 15см-ээс багагүй хэмжээгээр өргөгдсөн байх эсхүл бургас тарьсан ногоон зүлгээр тусгаарлагдсан байх ёстой. Явган хүний зам нь хатуу хучилттай, ус зайлуулахад зориулагдсан налуутай байна.

7.7.3 Авто замын техникийн нөхцөл байдал нь ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлагыг хангасан байна.

7.7.4 Автомашин зогсох талбайг авто замын зорчих хэсгээс тусдаа, тусгайлан зориулсан талбайд байгуулна.

7.7.5 Авто зогсоолын талбайн хэмжээ нь автомашины тоо, төрөлд нийцсэн байна.

7.7.6 Автотээврийн хэрэгслийн төрөл ба чиргүүл дээрээ тээвэрлэх усан замын тээврийн хэрэгслийн төрлөөс хамааруулан нэг автомашин зогсох зогсоолын талбайн хэмжээг тогтооно. Нэг авто зогсоолын талбайн өргөн дараах хэмжээтэй байна. Үүнд:

7.7.7 автомашины өргөн 2,75 м хүртэл байх тохиолдолд 3,50 м;

7.7.8 автомашины өргөн 2,75 м-ээс илүү байх тохиолдолд 4,50 м.

7.7.9 Цул резинэн дугуй бүхий ачигч машин механизм, чирэгч машин механизм болон аккумуляторт тэрэгний ажиллах нөхцөлийг хангах зорилгоор зам талбайн хучилт нь асфальтбетон эсхүл мод /банзаар хийсэн байна.

7.8 Технологийн цогцолборын тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд тавих шаардлага

7.8.1 Зогсоолын технологийн цогцолборын объектуудыг гадаргуугийн болон газрын гүний ус, залгаа орших нутаг дэвсгэр, агаар мандлыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх болон зогсоолын технологийн цогцолборын экологийн аюулгүй байдлыг бүхэлд нь хангасан хэрэгслүүдээр тоногловсон байна.

7.8.2 Зогсоолын технологийн цогцолборын тоног төхөөрөмжүүд нь угсрах суурилуулах, задлах буулгах, ашиглалтад оруулах, ашиглалтын баримт бичигт заасан шаардлагыг мөрдсөн үед технологийн цогцолборын дэд бүтцийн объектууд, эргийн болон хөвөгч байгууламжийн технологийн шугамуудын бүрэлдэхүүнд ашиглагдахдаа аюулгүй байдлыг хангасан байна.

7.8.3 Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага нь ГОСТ Р 57618.4 стандартад нийцсэн байна.

ТӨГСӨВ.

Ном зүй

- (1) СанПиН 2.2.1/2.1.1.1200-03 Эрүүл ахуй - халдвар хамгааллын бүсүүд ба үйлдвэр, байгууламж болон бусад объектуудын эрүүл ахуй -ариун цэврийн ангилал
- (2) СНиП III-10-75 Үйлдвэрлэл явуулах дүрэм ба ажлыг хүлээн авах. Нутаг дэвсгэрийг тохижуулах
- (3) “Барилга, байгууламжийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлага” ОХУ-ын 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Холбооны хууль № 384-ФЗ
- (4) Үйлдвэрийн аюултай объектуудын үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах тухай ОХУ-ын 1997 оны 7 дугаар сарын 21-ний өдөр (2017 оны 3 дугаар сарын 7-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан) -ийн Холбооны хууль № 116-ФЗ, (2017 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийн хамт)
- (5) НПБ 105-95 Тэсэрч дэлбэрч гал гарах аюултай болон гал түймрийн аюултай барилга, байгууламжийн ангилал, зэрэглэлийг тодорхойлох
- (6) “Галын аюулгүй байдалд тавих техникийн шаардлагын техникийн зохицуулалт” ОХУ-ын 2008 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Холбооны хууль № 123-ФЗ
- (7) СНиП 21-01-97 Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал (2002 оны 7 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан)
- (8) Цахилгаан тоног төхөөрөмж суурилуулалтын дүрэм. Долоо дахь хэвлэл (ОХУ-ын Эрчим хүчний сайдын 2002 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн № 204 дүгээр тушаалаар батлагдсан)